



Г

“НЭТС ПРОПЕРТИС” ХХК-Д

Г

## САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРОО

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,  
Бага тойруу 3, Засгийн газрын IV байр,  
Утас: 26-44-44, Факс: (976-11) 32-90-84,  
E-mail: [info@frc.mn](mailto:info@frc.mn), <http://www.frc.mn>

2022.12.02 № ЦАТ-11/03/047

танай 2022.11.02 -ны № 22/103-Т

Г

Агентын өөрчлөлтийг бүртгэсэн тухай

Г

Танай компаниас агентын өөрчлөлтийг бүртгүүлэх тухай хүсэлт, холбогдох баримт бичиг ирүүлснийг Хорооны 2020 оны 120 дугаар тогтоолоор баталсан “Үл хөдлөх эд хөрөнгө зуучлалын байгууллагын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл, зөвшөөрөл, эрх олголт, бүртгэлийн журам”-ын дагуу хянаж, нэр бүхий 3 агент буюу Болдбаатарын Энхсайхан, Гаахүүгийн Батзаяа, Намхайгийн Эрдэнэтуяа нарыг тус Хорооны нэгдсэн бүртгэлээс хасаж, өөрчлөлтийг хийсэн болохыг мэдэгдье.

Дээрх журмын 6.5-д “Үл хөдлөх эд хөрөнгө зуучлалын байгууллагын үйл ажиллагаа эрхлэх хуулийн этгээдийн агент өөрчлөгдөх, шинээр томилогдсон тухай мэдээллийг албан бичгээр улирал бүрийн дараа сарын 10-ны өдрийн дотор Хороонд холбогдох баримт бичгийн хамт ирүүлж, бүртгүүлнэ” гэж заасны дагуу агентын өөрчлөлтийг Санхүүгийн Зохицуулах Хороонд бүртгүүлж ажиллахыг анхаарна уу.

Жич: Дээрх албан бичгээр Лхагвасүрэнгийн Номинцэцэг агентыг бүртгэлээс хасуулах тухай хүсэлт ирүүлснийг хянахад танай компанийн бүртгэлд тус агент нь бүртгэлгүй байгаа тул хасах боломжгүй. Мөн Нармандахын Түвшинсайханыг агентаар нэмж бүртгүүлэх тухай хүсэлт ирүүлсэн боловч Н. Түвшинсайхан нь ажлаасаа гарсан гэж мэдэгдсэн тул бүртгэх шаардлагагүй болно.

ҮЛ ХӨДЛӨХ ХӨРӨНГӨ ЗУУЧЛАЛ,  
ҮНЭТ ЭДЛЭЛИЙН ЗОХИЦУУЛАЛТЫН  
ГАЗРЫН ДАРГЫН ҮҮРГИЙГ  
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ

Н.ЭНХТУЯА

